



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 25 өдөр

Дугаар А/682

Мөрөн сум

Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх арга
хэмжээний жагсаалт батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны төсөвт, хэрэгжих арга хэмжээний хөтөлбөрөөр батлагдсан зардлын задаргаа, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, арга хэмжээ, санхүүжүүлэх мөнгөн дүнгийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан төсвийг хавсралтын дагуу санхүүжүүлж, тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх), засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Д.Балжинням) нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Базар)- д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

Аймгийн Засаг даргын 2023 оны
12 дугаар сарын 25 өдрийн
А/682 дугаар захирамжийн
хавсралт
/мян.төг-өөр/

Хөтөлбөрийн нэр	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Санхүүжүүлэх дүн	Хөтөлбөрийн дүн
Боловсрол шинжлэх ухааны бодлого удирдлага	Багш нарын ур чадварын уралдаан, сурган хүмүүжүүлэх илтгэлийн уралдаан, хичээл төрлийн олимпиад зохион байгуулах	60,500.0	125,000.0
	Улсын физикийн олимпиад зохион явуулах	45,000.0	
	Бага насны хүүхдийн ялгаатай байдалд тулгуурлан хөгжүүлэх дугуйлан хичээллүүлэх	1,500.0	
	Багш нарын мэргэжил дээшлүүлэх танхимын болон цахим сургалтыг зохион байгуулах	18,000.0	
Эрүүл мэндийн бодлого удирдлага	Шинэ болон сэргэн тархаж байгаа халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангуулах	9,000.0	49,000.0
	Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг чадавхижуулах, тогтвортой ажиллуулах арга хэмжээг хэрэгжүүлэх	40,000.0	
Биеийн тамир спортын арга хэмжээ	"Хөвсгөл марофон 2024" тэмцээн зохион байгуулах	35,000.0	225,400.0
	Аэробик, Ширээний теннис, таеквондогын улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах	34,000.0	
	Өсвөрийн шигшээ баг бүрдүүлж ажиллуулж эхлэх	66,400.0	
	Тамирчдын амжилтыг үнэлж, урамшуулах	90,000.0	
Соёл урлаг	Угийн бичиг хөтлөх ажлыг эрчимжүүлэх	4,200.0	54,200.0
	Музейн үзмэрийн болон номын сангийн баяжилт хийх, сан хөмрөгийг нэмэгдүүлэх	20,000.0	
	Үндэсний бичгийн уншлагын танхимын сан хөмрөгийг нэмэгдүүлэн уншигч үйлчлүүлэгийн цар хүрээг нэмэгдүүлэх	10,000.0	
	"Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлж эдийн засгийн эргэлтэд оруулах нь" чуулган, үзэсгэлэн, Эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах	5,000.0	
	"Өв хамгаалал" хөтөлбөр хэрэгжүүлэх	15,000.0	
	Оны онцлох хүүхэд шалгаруулж, шагнаж урамшуулах	10,000.0	

Хөтөлбөрийн нэр	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Санхүүжүүлэх дүн	Хөтөлбөрийн дүн
Гэр бүлийн хөгжил хамгаалал	Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагааг тогтмолжуулах	10,000.0	100,000.0
	Хүчирхийллийн хохирогчдод үйлчлэх нэг цэгийн үйлчилгээний төвийн зардал, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах	80,000.0	
Ахмад настаны хөгжил хамгаалал	Улаан-уул сумын Ахмадын хороонд дэмжлэг үзүүлэх	10,000.0	50,000.0
	"Монголын ахмадын өдөр" арга хэмжээг зохион байгуулах	10,000.0	
	85-аас дээш настай ахмадуудад цагаан сараар хүндэтгэл үзүүлэх	30,000.0	
Хөдөлмөр эрхлэлтийн бодлого удирдлага	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн ажлыг тогтмолжуулж, сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулах	30,000.0	100,000.0
	Улаан загалмайн хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	40,000.0	
	Иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах	15,000.0	
	Хөдөлмөрийн хамтын гэрээ хэлэлцээрийг бүртгэж, үйл ажиллагааг дэмжих зардал	15,000.0	
Эрх зүй нийгмийн хэв журам	"Сэтгэл зүйчдийн баг"-ийн үйл ажиллагааг дэмжих зардал	15,000.0	368,133.6
	Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, салбарын онцлогт тохируулан ажил зохион байгуулах.	10,000.0	
	Хүний эрхийн талаарх мэдлэг олгох сургалт зохион байгуулах	5,000.0	
	Батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах	113,700.0	
	Тусгай зөвшөөрөл авсан ААН-д хяналт хэрэгжүүлэх. /Хуулийн хэлтэс/	40,000.0	
	Засаг даргад хуулиар олгосон үүрэг, эрх хэмжээний хүрээнд захиран зарцуулах, мөн мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт хангах	181,433.6	
	Захирамжлалын баримт бичгийн 80 хүртэл хувийг цахим хэлбэрт шилжүүлэх, тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх ажлын зардал	3,000.0	
	Гадаад хот, мужуудтай эдийн засаг, нийгмийн хамтын ажиллагааг өргөжүүлж, шинээр харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх	16,000.0	
	"Нээлттэй Хөвсгөл" хөтөлбөрийг хэрэгжүүлэх	50,000.0	

Хөтөлбөрийн нэр	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Санхүүжүүлэх дүн	Хөтөлбөрийн дүн
Төрийн албаны ерөнхий удирдлага зохицуулалт	Чиг үүргийн шинжилгээ хийх	10,000.0	353,215.7
	Аймгийн шагналын нөөц бүрдүүлэх	39,000.0	
	Хэвлэл мэдээллийн үйл ажиллагааны зардал	38,715.7	
	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардал	28,500.0	
	Багийн засаг дарга нарыг чадавхжуулах сургалт зохион байгуулах зардал	15,000.0	
	Хөдөөгийн 88 багт ажиллах зардал	50,000.0	
	Аймгийн вэб сайтын шинэчлэлтийн зардал	10,000.0	
	Цахим аймаг хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд мэдээллийн аюулгүй байдлын үзүүлэлт сайжруулах	20,000.0	
	Монголын баялаг 330 нэвтүүлгийн зардалд дэмжлэг үзүүлэх	40,000.0	
	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, "Мод тарьж ногоон суварга босгоё" аяны хүрээнд сумдын байгаль орчны тасгийн албан хаагчдийн чадавхжуулах, туршлага судлуулах зардал	36,000.0	
Санхүүгийн хяналт дотоод аудит, эрсдлийн удирдлага	Санхүүгийн ажилтнуудад сургалт зохион байгуулах, төрийн сангийн дотоод хяналтыг хэрэгжүүлэх, мэргэшсэн нягтлан бодогчдийн сургалт арга хэмжээ	29,800.0	44,800.0
	Татвар, орон нутгийн орлог бүрдүүлэхтэй холбоотой хуулиудыг аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд жигд хэрэгжүүлэх талаар зохион байгуулах арга хэмжээний зардал	10,000.0	
	Олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр мэргэжлийн байгууллагатай хамтарч ажиллах зардал	5,000.0	
	Аймгийн аварга малчин, саальчин, фермер, залуу аварга малчин гэр бүл, тариаланч, тариаланч хамт олон, шилдэг үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчидийг шалгаруулж шагнах зардал	74,000.0	
	"Намрын ногоон өдрүүд" арга хэмжээ зохион байгуулах, оролцох /аймагт 10.0 сая, хотод оролцоход 6.0 сая/	16,000.0	
	Шилмэл малын үзэсгэлэн худалдаа зохион байгуулах	15,700.0	

Хөтөлбөрийн нэр	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Санхүүжүүлэх дүн	Хөтөлбөрийн дүн
Мал аж ахуйг хөгжүүлэх	Эцэг малд ангилалт хийж, эмэглэх, ялган тэмдэглэх үйлчилгээ	40,000.0	189,700.0
	Малын бүртгэл мэдээллийг нэгдсэн санд оруулах	4,000.0	
	"Хөвсгөл Органик" арга хэмжээний хүрээнд малчин тариаланчдад чадавхжуулах сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах зардал	20,000.0	
	Үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч нарт зориулсан хүнсний сав баглаа боодлын стандартыг хангуулах сургалт зохион байгуулах	5,000.0	
	Өсвөр малын махан ашиг шимийг нэмэгдүүлэх судалгааны ажил хийх зардал	15,000.0	
Аялал жуулчлал	Эвэнт арга хэмжээ зохион байгуулах, аялал жуулчлалын чиглэлээр гадаад, дотоод үзэсгэлэн худалдаанд оролцох	135,000.0	165,000.0
	Эв модны наадам зохион байгуулах	30,000.0	
Барилга хот байгуулалт, нийтийн аж ахуйн бодлого	Хатгал тосгоны цэвэрлэх байгууламжид олгох татаас	80,000.0	430,000.0
	Залуучуудын хөгжлийн төвийн тогтмол зардал	78,000.0	
	Бизнес хөгжлийн төвийн тогтмол зардал	30,000.0	
	Уран дөш хүүхдийн зуслангийн үйл ажиллагааны зардал	50,000.0	
	ХТҮТ-ийн өр барагдуулах зардал	150,000.0	
	"Ид шидийн орон"-ы тогтмол зардал	42,000.0	
Дүн		2,254,449.3	2,254,449.3